

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/264/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН  
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: [saranchimegts@audit.gov.mn](mailto:saranchimegts@audit.gov.mn)

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: [auditulziit@gmail.mn](mailto:auditulziit@gmail.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан. ....	11
2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2 Материаллаг байдал .....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	22

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэл осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 4/129

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
И.ОТГОН-ЭРДЭНЭ ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Төв аймгийн Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй бөгөөд бидний мэргэжлийн шийдлийн үнэлэмжээр, сонгон авсан горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээг багтаан санхүүгийн тайланд аудитын ажлыг гүйцэтгэхэд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан авч үзсэн бөгөөд аудитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн асуудлууд байхгүй байна.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээг дараах байдлаар тодорхойлж байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

019020230

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>113,303,004.85</b>	<b>111,084,161.98</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>32,707,540.47</b>	<b>22,086,728.74</b>
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>32,707,540.47</b>	<b>22,086,728.74</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>32,707,540.47</b>	<b>22,086,728.74</b>
<b>31</b>	Төрийн сангийн харилцах	32,707,540.47	22,086,728.74
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>3,153,947.68</b>	<b>123,660.93</b>
335	Бусад авлага	3,153,947.68	123,660.93
3351	Байгууллагаас авах авлага	153,947.68	123,660.93
3352	Хувь хүнээс авах авлага	3,000,000.00	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>77,441,516.70</b>	<b>88,873,772.31</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>11,209,465.20</b>	<b>18,693,865.20</b>
<b>35110</b>	<b>Тусгай зориулалттай материал</b>	<b>11,209,465.20</b>	<b>18,693,865.20</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>66,232,051.50</b>	<b>70,179,907.11</b>
35410	Бичиг хэргийн материал	413,450.00	440,450.00
35420	Аж ахуйн материал	58,229,407.00	60,912,807.00
35440	Түлш шатах тослох материал	2,286,600.00	1,928,417.11
35450	Барилгын засварын материал	4,216,400.00	4,335,400.00
35460	Хүнсний материал	451,194.50	1,701,133.00
35470	Бусад хангамжийн материал	635,000.00	861,700.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,407,514,003.58</b>	<b>2,132,695,368.63</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,407,514,003.58</b>	<b>2,132,695,368.63</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,335,472,003.58</b>	<b>2,060,653,368.63</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,401,607,299.15	2,133,660,839.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	(137,275,689.78)	(193,919,178.54)
39205	Машин тоног төхөөрөмж	105,449,529.17	137,132,529.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	(61,744,288.54)	(71,263,386.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,264,712.05	59,585,812.05
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,977,265.71)	(12,297,480.35)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,365,000.00	19,365,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,608,610.76)	(15,809,999.68)
39217	Номын фонд	3,391,318.00	4,199,233.68
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>72,042,000.00</b>	<b>72,042,000.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	72,042,000.00	72,042,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,520,817,008.43</b>	<b>2,243,779,530.61</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>12,884,022.19</b>	<b>750,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>12,884,022.19</b>	<b>750,000.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>12,884,022.19</b>	<b>750,000.00</b>
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	12,884,022.19	
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>		<b>750,000.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг		750,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,507,932,986.24</b>	<b>2,243,029,530.61</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,507,932,986.24</b>	<b>2,243,029,530.61</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	276,502,951.31	276,502,951.31
51101	Өмч:-төрийн	276,502,951.31	276,502,951.31
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>283,308,460.50</b>	<b>1,018,405,004.87</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	283,308,460.50	283,308,460.50
51220	Тайлант үеийн үр дүн		735,096,544.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	948,121,574.43	948,121,574.43
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,520,817,008.43</b>	<b>2,243,779,530.61</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,185,113,943.87</b>	<b>1,514,707,903.68</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,551,971,943.87</b>	<b>780,004,455.68</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,551,971,943.87</b>	<b>780,004,455.68</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,551,971,943.87	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,551,971,943.87	
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		779,504,455.68
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		500,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>113,790,500.00</b>	<b>88,823,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	519,351,500.00	645,879,548.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>37,168,200.00</b>	
131104	Дээд шатны төсвийн захирагчаас тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	37,168,200.00	
	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>76,622,300.00</b>	<b>88,823,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага /	76,622,300.00	88,823,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>670,441,478.80</b>	<b>779,611,359.31</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>669,836,478.80</b>	<b>779,611,359.31</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>623,044,623.89</b>	<b>779,611,359.31</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>392,761,219.76</b>	<b>513,181,942.49</b>
210101	Үндсэн цалин	283,967,988.92	326,543,846.50
210102	Нэмэгдэл	94,443,767.53	160,939,058.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,000.00	
210104	Урамшуулал	14,305,463.31	25,699,037.71
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>48,619,148.84</b>	<b>52,978,903.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	33,206,125.93	37,038,939.20
210202	Тэтгэмжийн даатгал	4,064,184.02	4,227,583.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,186,381.35	2,983,498.97
210204	Ажилгүйдлийн даатгал	806,800.71	746,640.44
210205	Эрүүл мэндийн даатгал	7,355,656.83	7,982,241.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>62,204,743.39</b>	<b>74,298,060.70</b>
210301	Гэрэл, цахилгаан	12,749,688.19	18,527,559.30
210302	Түлш, халаалт	49,455,055.20	55,770,501.40
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,852,890.00</b>	<b>1,214,500.00</b>
210401	Бичиг хэрэг	1,782,100.00	1,214,500.00
<b>210406</b>	<b>Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс</b>	<b>4,070,790.00</b>	
<b>210408</b>	<b>Бараа материал акталсны зардал</b>	<b>2,000,000.00</b>	
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>39,006,270.02</b>	<b>51,075,661.50</b>
210501	Эм	247,500.00	
210502	Хоол, хүнс	38,758,770.02	51,075,661.50
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,105,930.00</b>	<b>2,280,740.00</b>
210604	Урсгал засвар	6,105,930.00	2,280,740.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>747,900.00</b>	<b>2,437,800.00</b>
210806	Мэдээллийн технологийн хөлс	747,900.00	2,437,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>65,746,521.88</b>	<b>82,143,750.63</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,414,650.00	7,744,560.00

Төв аймгийн Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,177,700.00	715,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,154,171.88	73,684,190.63
<b>27</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>46,791,854.91</b>	
	Бусад урсгал шилжүүлэг	41,519,700.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж , урамшуулал	4,351,500.00	
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас , санхүүжилт	5,272,154.91	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,864,400.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	19,303,800.00	
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,272,154.91	
28	Хөрөнгийн зардал	605,000.00	
	Дотоод эх үүсвэрээс	605,000.00	
220001	Барилга байгууламж	605,000.00	
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,514,672,465.07</b>	<b>735,096,544.37</b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>6,737,690.49</b>	
<b>225001</b>	<b>Үндсэн хөрөнгө худалдсаны гарз</b>	<b>6,737,690.49</b>	
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>	<b>(6,737,690.49)</b>	
	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,507,934,774.58</b>	<b>735,096,544.37</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>276,502,951.31</b>	<b>953,963,097.78</b>	<b>(14,123,876.06)</b>	<b>1,216,342,173.03</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(1,210,502,438.02)	(1,210,502,438.02)
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>276,502,951.31</b>	<b>953,963,097.78</b>	<b>(1,224,626,314.08)</b>	<b>5,839,735.01</b>
Тайлант үеийн үр дүн			1,507,934,774.58	1,507,934,774.58
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>276,502,951.31</b>	<b>948,121,574.43</b>	<b>283,308,460.50</b>	<b>1,507,932,986.24</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн</b>	<b>276,502,951.31</b>	<b>948,121,574.43</b>	<b>283,308,460.50</b>	<b>1,507,932,986.24</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/			735,096,544.37	735,096,544.37
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>276,502,951.31</b>	<b>948,121,574.43</b>	<b>1,018,405,004.87</b>	<b>2,243,029,530.61</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>633.142.000.00</b>	<b>734,703,448.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>633,142,000.00</b>	<b>734,703,448.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	519,351,500.00	645,879,548.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого	37,168,200.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид	37,168,200.00	
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76,622,300.00	88,823,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага /	76,622,300.00	88,823,900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>592,939,559.53</b>	<b>725,963,159.73</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>592,939,559.53</b>	<b>725,963,159.73</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>536,467,604.62</b>	<b>703,493,359.73</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>391,464,510.13</b>	<b>510,151,655.74</b>
210101	Үндсэн цалин	282,226,203.82	323,513,559.75
210102	Нэмэгдэл	94,810,911.82	160,939,058.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,000.00	
210104	Урамшуулал	14,383,394.49	25,699,037.71
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>53,051,594.49</b>	<b>52,978,903.99</b>
210201	Тэтгэврийн даатгал	36,075,036.24	37,038,939.20
210202	Тэтгэмжийн даатгал	4,244,139.57	4,227,583.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,395,251.64	2,983,498.97
210204	Ажилгүйдлийн даатгал	848,887.92	746,640.44
210205	Эрүүл мэндийн даатгал	8,488,279.12	7,982,241.52
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>46,519,300.00</b>	<b>86,823,900.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,161,121.19	20,235,084.72
210302	Түлш, халаалт	29,358,178.81	66,588,815.28
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>24,243,700.00</b>	<b>29,355,800.00</b>
210502	Хоол, хүнс	24,243,700.00	29,355,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	2,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,384,200.00</b>	<b>2,437,800.00</b>
210806	Мэдээллийн технологийн хөлс	3,384,200.00	2,437,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>16,804,300.00</b>	<b>19,745,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,443,800.00	17,202,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,360,500.00	2,543,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>56,471,954.91</b>	<b>22,469,800.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>51,199,800.00</b>	<b>22,469,800.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	14,031,600.00	22,469,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,864,400.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	19,303,800.00	
	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас , санхүүжилт</b>	<b>5,272,154.91</b>	
	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,272,154.91	

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	40,202,440.47	8,740,288.27
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	7,494,900.00	19,361,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,494,900.00	19,361,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,494,200.00	19,361,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(7,494,900.00)	(19,361,100.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	32,707,540.47	(10,620,811.73)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0,00	32,707,540.47
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	32,707,540.47	22,086,728.74

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>32,707,540.47</b>	<b>(32,707,540.47)</b>	
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>767,410,988.47</b>	<b>745,324,259.73</b>	<b>22,086,728.74</b>	<b>97.1%</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>767,410,988.47</b>	<b>745,324,259.73</b>	<b>22,086,728.74</b>	97.1%
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>741,556,988.47</b>	<b>722,854,459.73</b>	<b>18,702,528.74</b>	97.5%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	531,317,000.00	510,151,655.74	21,165,344.26	96.0%
Үндсэн цалин	358,457,200.00	323,513,559.75	34,943,640.25	90.3%
Нэмэгдэл	156,250,200.00	160,939,058.28	(4,688,858.28)	103.0%
Урамшуулал	16,609,600.00	25,699,037.71	(9,089,437.71)	154.7%
<b>Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл</b>	<b>66,301,240.47</b>	<b>52,978,903.99</b>	<b>13,322,336.48</b>	79.9%
Тэтгэврийн даатгал	45,016,040.47	37,038,939.20	7,977,101.27	82.3%
Тэтгэмжийн даатгал	5,321,200.00	4,227,583.86	1,093,616.14	70.1%
ҮОМШӨ-ний даатгал	4,257,100.00	2,983,498.97	1,273,601.03	70.2%
Ажилгүйдлийн даатгал	1,064,300.00	746,640.44	317,659.56	70.2%
Эрүүл мэндийн даатгал	10,642,600.00	7,982,241.52	2,660,358.48	75.0%
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>86,823,900.00</b>	<b>86,823,900.00</b>		100.0%
Гэрэл, цахилгаан	20,235,084.72	20,235,084.72		100.0%
Түлш, халаалт	66,588,815.28	66,588,815.28		100.0%
<b>Норматив зардал</b>	<b>29,355,800.00</b>	<b>29,355,800.00</b>		100.0%
Хоол, хүнс	29,355,800.00	29,355,800.00		100.0%
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>		100.0%
Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00		100.0%
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>3,465,400.00</b>	<b>2,437,800.00</b>	1,027,600.00	70.3%
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,027,600.00		1,027,600.00	100.0%
Мэдээллийн технологийн зардал	2,437,800.00	2,437,800.00		100.0%
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>22,293,648.00</b>	<b>39,106,400.00</b>	<b>(16,812,752.00)</b>	175.4%
Бараа үйлчилгээний бусад зардал	18,637,048.00	35,449,800.00	(16,812,752.00)	190.2%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,656,600.00	3,656,600.00		100.0%
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,854,000.00</b>	<b>22,469,800.00</b>	<b>3,384,200.00</b>	<b>86.9%</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,854,000.00</b>	<b>22,469,800.00</b>	<b>3,384,200.00</b>	<b>86.9%</b>
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж	25,854,000.00	22,469,800.00	3,384,200.00	86.9%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>768,438,588.47</b>	<b>734,703,448.00</b>	<b>33,735,140.47</b>	<b>95.6%</b>
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	646,907,148.00	645,879,548.00	1,027,600.00	99.8%
Улсын төсвөөс санхүүжих	646,907,148.00	645,879,548.00	1,027,600.00	99.8%
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>88,823,900.00</b>	<b>88,823,900.00</b>		<b>100.0%</b>

Төв аймгийн Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Орон нутгийн төсвөөс	88,823,900.00	88,823,900.00		100.0%
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>	<b>32,707,540.47</b>		<b>32,707,540.47</b>	
Урд оны үлдэгдлээс санхүүжих	32,707,540.47		32,707,540.47	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>32,707,540.47</b>	<b>(32,707,540.47)</b>	
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>22,086,728.74</b>	<b>(22,086,728.74)</b>	
АЖИЛЛАГСДЫН ТОО	28	28	28	100%
Удирдах ажилтан	1	1	1	100%
Гүйцэтгэх ажилтан	15	15	15	100%
Үйлчлэх ажилтан	12	12	12	100%

## 2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>88,823,900.00</b>	<b>88,823,900.00</b>		<b>100.0%</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>88,823,900.00</b>	<b>88,823,900.00</b>		<b>100.0%</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>88,823,900.00</b>	<b>88,823,900.00</b>		<b>100.0%</b>
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>88,823,900.00</b>	<b>88,823,900.00</b>		<b>100.0%</b>
Гэрэл, цахилгаан	20,235,084.72	20,235,084.72		100.0%
Түлш, халаалт	66,588,815.28	66,588,815.28		100.0%
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>2,000,000.00</b>		<b>100.0%</b>
Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00		100.0%
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>88,823,900.00</b>	<b>88,823,900.00</b>		<b>100.0%</b>
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>88,823,900.00</b>	<b>88,823,900.00</b>		<b>100.0%</b>
Орон нутгийн төсвөөс	88,823,900.00	88,823,900.00		100.0%
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>				
АЖИЛЛАГСДЫН ТОО	28	28	28	100%
Удирдах ажилтан	1	1	1	100%
Гүйцэтгэх ажилтан	15	15	15	100%
Үйлчлэх ажилтан	12	12	12	100%

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сургалтын болон сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлсэн, сургалтын чанар, багш, сурагчдын чадварыг дээшлүүлж, уламжлал шинэчлэлийг хослуулсан хүүхдэд ээлтэй, эрүүл чийрэг, эерэг зан суртахуун, хүмүүжил, төлөвшилтэй, амьдрах ухаантай, эх оронч, үндэсний бахархалтай иргэн төлөвшүүлнэ гэж эрхэм зорилгоо тодорхойлсон байна.

Байгууллага нь нийт 28 багш, 184 сурагчидтай сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг явуулж байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын ерөнхий боловсролын сургууль нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилт, хэрэгжүүлэх 45 арга хэмжээтэй баталснаас нийт 84.8%-тай дүгнэгдсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын ерөнхий боловсролын сургууль нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас хяналт, шалгалтын ажил хийгдэн цалин хөлс, илүү олгосон шагнал урамшуулал, ажиллагсдын өр төлбөртэй холбоотой асуудалд 10,646.9 мянган төгрөгийн төлбөрийн акт хүргүүлсэн байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Сэргэлэн сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Сэргэлэн сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 722,962.6 мянган төгрөгөөр буюу 47.5 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	32,707.5	22,086.7	(10,620.8)
Авлага	3,153.9	123.7	(3,030.2)
Бараа материал	77,441.5	88,873.7	11,432.3
Үндсэн хөрөнгө	1,407,514.0	2,132,695.4	725,181.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,520,816.9</b>	<b>2,243,779.5</b>	<b>722,962.8</b>
Өглөг	12,884.0	750.0	(12,134.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,507,932.9	2,243,029.5	735,096.6
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,520,816.9</b>	<b>2,243,779.5</b>	<b>722,962.6</b>

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 10,620.8 мянган төгрөгөөр буурсан нь гүйцэтгэлээр санхүүждэг болсонтой холбоотой.

Авлага дансны үлдэгдэл 123.7 мянган төгрөг болж 3,030.2 мянган төгрөг болж буурсан нь ажиллагсадаас авах авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материал данс 11,432.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн аж ахуйн бараа материалын үлдэгдэл 2,683.4 мянган төгрөг, тусгай зориулалтын материал 7,484.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, мөн 500.0 мянган төгрөгийн бараа материалыг хувь хүнээс үнэ төлбөргүй хүлээн авснаар нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж 732,056.5 мянган төгрөг, тоног төхөөрөмж 31,683.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 34,321.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант онд сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр 452,005.7 мянган төгрөгийн дотуур байр сургуулийн засвар үйлчилгээ, аймгийн хөрөнгө оруулалтаар 212,144.0 мянган төгрөгийн сургуулийн их засвар, компьютер техник хэрэгсэл, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 833.9 мянган төгрөгийн ном хэрэгсэл, хувь хүн 9,444.0 мянган төгрөгийн ширээ сандал үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 750.0 мянган төгрөг болж буурсан нь өмнөх оны ашиглалтын зардлыг төлж барагдуулсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,243,029.5 мянган төгрөг болж 735,096.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 546,551.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 58,347.7 мянган төгрөг, нийт 604,898.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын ерөнхий боловсролын сургууль нь дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 130,832.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2023 оны урсгал зардлын төсвийг 735,731.1 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 735,731.1 мянган төгрөгөөс 1 удаа тодотгол хийж 735,731.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 734,703.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авч зарцуулсан байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 734,703.5 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байна.

Хүснэгт 2.

<i>/мянган төгрөг/</i>					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.1	80266-Байр ашиглалтын үйлчилгээ	975.1	975.1	0	100 %
1.2	80312-Сургалт, семинар	487.6	487.6		100 %
1.3	81605-Эрүүл мэндийг дэмжих	975.1	975.1		100 %
1.4	81801-Үдийн цай хөтөлбөр	25,854.1	22,469.8	3,384.3	86.9%
1.5	81806-Дотуур байрны үйлчилгээ	52,193.9	48,459.8	3,734.1	82.3%
1.6	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	10,268.9	10,254.8	14.1	99.8%
1.7	81823-Боловсролын байгууллагын багш, ажилчдын мэргэжил дээшлүүлэх	2,194.0	1,975.0	219.0	85,8%
1.8	81827-Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	1,610.0	1,505.1	104.9	20.6%
1.9	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	436,992.8	440,228.4	3,235.6	94%
1.10	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	114,177.5	110,022.4	4,155.1	99.9%
1.11	81844-Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	150.6	150.6		100%
1.12	81848-Сурах бичгийн түрээс	1,027.6	1,027.6		94.3%
1.13	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	88,823.9	88,823.9		100%
	<b>Дүн</b>	<b>735,731.1</b>	<b>727,355.2</b>	<b>8,375.9</b>	<b>97.1%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Сэргэлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 170,984.9 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ

худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: 95,543.9 мянган төгрөгийн үдийн цай болон дотуур байрны хүүхдийн хоол хүнс, бичиг хэрэг, шуудан холбооны зардлын 59,760.0 мянган төгрөгөөр шууд худалдан авахаар, шалгаруулахаар, 75,440.9 мянган төгрөгийн гэрэл цахилгаан, цэвэр бохир усны зардлыг шууд гэрээ байгуулахаар тус бүр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 170,984.9 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн. Худалдан авалтын дүн өссөн нь түлш халаалтын үнэ нэмэгдсэн, сурагчдын тоо нэмэгдсэнтэй холбоотой.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн 2 зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав хэрэгжүүлж, дараагийн хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Сэргэлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 23 -ны өдрийн 24 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Сэргэлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Сэргэлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлага 670,441.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 10,056.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,542.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Төв аймгийн Сэргэлэн сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,027.6 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 159 мэдээллээс 159 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн шууд захирагчийн мэдээлбэл зохих 159 мэдээллээс 153 мэдээллийг хуулийн хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй, 2 мэдээллийн мэдээлэх хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн 351,186.4 мянган төгрөгийн 5 мэдээллийг байршуулаагүй нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн: Хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй тул нийцсэн гэж дүгнэлээ.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Төв аймгийн Сэргэлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитыг “Их Монгол хөлөг аудит” ХХК нь хийж гүйцэтгэсэн бөгөөд дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Сэргэлэн сумын ерөнхий боловсролын сургуулийн дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### 5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 195,046.4 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залрууллаа.Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн улсын төсвийн санхүүжилтийг 189,046.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнг 4,500.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3. Санхүү байдлын тайлангийн нийт өр төлбөрийн дүнг 1,500.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан “Төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах” гэсэн заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар 2,896.1 мянган төгрөгийн алдаа илэрснээс, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлж, 2,896.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 5.1 Албан шаардлага

Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэж, тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д “төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлээ,

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-т “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ”; Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэж заасныг үндэслэн хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Анхан шатны баримтын бүрдэл хангахтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэл хангаагүй 2,896.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь НӨАТ-ын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13-д "нэмэгдсэн өртгийн албан татварын падаан" гэж тухайн төлбөр тооцоо хийснийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар, албан татвар суутган төлөгчийн буюу худалдаа эрхлэгч, худалдан авагч албан татвар суутган төлөгчийн нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримт", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ****6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан санхүүжилтийг дутуу тусгасан	1	189,046.4	1	189,046.4			1	189,046.4				
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг дутуу бүртгэсэн	1	4,500.0	1	4,500.0			1	4,500.0				
Өр төлбөрийг илүү тайлагнасан	1	1,500.0			1	1,500.0	1	1,500.0				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>195,046.4</b>	<b>2</b>	<b>193,546.4</b>	<b>1</b>	<b>1,500.4</b>	<b>3</b>	<b>195,046.4</b>				

**6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу, мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээ хийсэн	1	2,896.1					1	2,896.1				
Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд бэлтгэн ирүүлээгүй	1	-							1	-		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>2,896.1</b>					<b>1</b>	<b>2,896.1</b>	<b>1</b>	<b>-</b>		

**6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хүрээнд мэдээлбэл зохих 351,186.4 мянган төгрөгийн 5 мэдээг хуулийн хугацаанд байршуулаагүй байна.	5	351,186.4						5	351,186.4
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>351,186.4</b>						<b>5</b>	<b>351,186.4</b>



ТӨВ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 27 өдөр

Дугаар \_\_\_\_\_

99-17225502-ТӨА-2024/264/НА-СТА-ТШЗ

Зуунмод

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үүнд:

Тус байгууллагын нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа төсвийн тухай хуулийн цагалбарт хугацаанд бэлтгээгүй, аудитад шаардлагатай нотлох баримтуудыг бүрэн ирүүлж ажиллаагүй байна.

Энэ Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-д "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Зөрчил гаргасан нягтлан бодогч Ч.Одбаярт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

<sup>1</sup>Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040434

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Сэргэлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал И.Отгон-Эрдэнэ, нягтлан бодогч Ч.Одбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ